

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 09 ДҮГЭЭР САРД
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ**

2022.09.30

Сайншанд сум

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР:

НЭГ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

Хүний нөөцийн чиглэлээр:

Аймгийн Засаг даргын Тамгын газарт ажлаас чөлөөлсөн 5, ажлаас чөлөөлж томилсон 3, шинээр ажилд томилсон 1, сургалтын төлбөрийн дэмжлэгийн 2 тушаал баталсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарын болон үйл ажиллагааны чиглэл, хэлтсийн нэр өөрчлөгдсөн зарим албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар баталсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дотоод журамд өөрчлөлт оруулан А/98 тушаалаар, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн А/99 тушаалаар, Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн А/100 тушаалаар тус тус баталсан.

Аймгийн Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгод хөтөлбөрийн төслийг боловсруулсан.

Дотоод ажил:

Аймгийн Засаг даргын Захирамж А- 43, Захирамж Б- 3, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын Тушаал А- 14, Тушаал Б-11 батлагдсан байна. Үүнээс аймгийн Засаг даргын 43 А Захирамжийг сайтад байршуулсан.

Аймгийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний саналыг хэлтсүүдээс авч нэгтгэн удирдлагад танилцуулсан.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх “Багийн нэр батлуулах” асуудлын дагуу хуралд хэлэлцүүлэх баримт бичгийн бүрдлийн төслийг бүрдүүлж дууссан.

Сумдад зохион байгуулагдсан томоохон ажлаас:

2022.09.16, 17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд”, “Шилмэл мал” арга хэмжээнд бүх сумд тариалан, гар урлал, хоол үйлдвэрлэл зэрэг чиглэлээр оролцсон.

2022.09.15ны өдөр Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулсан “Хүн амын богино хугацааны шилжилт хөдлгөөнийг тандах” туршилт судалгаа зохион байгуулагдахтай холбогдуулан Багийн Засаг дарга нар сургалтанд хамрагдсан.

2022.09.26, 27-ны өдүүдэд “Үр дүнд суурилсан төлөвлөлт болон төсөвлөлтийг нэвтрүүлэх нь” сургалтад 14 сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хөдөө аж ахуйн чиглэлийн мэргэжилтнүүд, санхүүгийн албаныхан оролцсон.

2022.09.30, 10.01-ны өдрүүдэд зохион байгуулсан “Ахмадын баяр”-ын арга хэмжээнд сумдууд урилгын дагуу ахмадуудаа хамруулсан.

Өргөдөл, гомдол, шагнал:

Энэ сард иргэдээс аймгийн Засаг дарга, Тамгын газарт хандаж өссөн дүнгээр 314 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс:

Бичгээр -195,

Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс – 109

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах

7052-11-11 утсаар болон <http://dornogovi.gov.mn/> сайт хаягаар – 10 өргөдөл санал ирсэн байна.

Өмнөх сард хүлээн аваад судлагдаж байсан 32 өргөдөлд хариуг өгч, 18 өргөдөл судлагдаж байна.

Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс ирүүлсэн 109 өргөдлийг хүлээн авч 86-ийг шийдвэрлэн хариуг өгч, 23 нь судлагдах шатандаа байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүлээн авах утсаар 10 иргэний өргөдөл саналыг хүлээн авч судалж шийдвэрлэх хэлтэс албан тушаалтанд шилжүүлэн 8 өргөдлийг шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7052-11-11 утсаар 355 санал, лавлагаа хүлээн авч холбогдох албан тушаалтанд дамжуулан, хариуг өгөв.

Хүлээн авсан нийт өргөдөл, гомдлын 98,8 хувь нь санал, хүсэлт, 0.4 хувь нь талархал, 0,6 хувь нь гомдол байв.

Төрийн дээд шагнал алдар цол, одон, медалиар шагнуулахаар нийт 136 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч дэмжих санал авахаар харъяалах төрийн төв байгууллагад хүргүүлж, дэмжсэн санал ирсэн 128 иргэний шагналын материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулахаар материал ирүүлсэн 86 иргэний тодорхойлолт материалыг хүлээн авч бүртгэн аймгийн Засаг даргын “Жуух”-аар 30 иргэнийг, “Өргөмжлөл”-өөр 56 иргэнийг шагнах тухай захирамж боловсруулж батлуулав.

Гадаад харилцааны чиглэлээр:

2016 оноос хойшх Дорноговь аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагаатай холбоотой албаны баримт бичиг, мэдээллийг нэгтгэж, аймгийн гадаад харилцааны дата баазыг үүсгэсэн.

БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газраас 9 дугаар сарын 26-нд зохион байгуулсан “Хятад Монгол улсын Найрсаг хамтын ажиллагааны цахим форум”-ын бэлтгэл ажлыг ханган "Хятад, Монголын найрсаг харилцааны хөгжил, цар тахлын хүнд үед хэрхэн бие биедээ туслах, цаашид Хятад, Монголын найрсаг харилцааг хэрхэн хөгжүүлэх " тухай аймгийн Засаг даргын илтгэлийг бэлтгэсэн.

Дорноговь аймаг, Шизуока мужийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй богино хугацааны чадавхжуулах сургалтад хамрагдах албан хаагчдын материалыг бүрдүүлж, Шизуока мужийн ЗДТГ-т хүргэсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-ын дарга Г.Сансармаа 09 дугаар сарын 07-16-ны өдрийг хүртэл тус мужид сургалтад хамрагдаад ирсэн бол 2-р ээлжинд Аймгийн ЗДТГ-1, Чандмань-Илч ХХК-5 инженер, албан хаагчид 10 дугаар сарын 10-20-ны хооронд сургалтад хамрагдана.

БНХАУ байгуулагдсаны 73 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын мэндчилгээг БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газарт болон хамтын ажиллагаатай Хөх хот, Эрэн хот, Бугат хот, Дархан Муумянган холбоот хошууны Гадаад харилцааны холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлсэн.

2022.09.26-ны өдөр ХЯТАД, МОНГОЛ УЛСЫН НАЙРСАГ ХАРИЛЦААНЫ ФОРУМ-д аймгийн Засаг дарга О.Батжаргал цахимаар оролцож “Хятад - Монголын найрсаг харилцааны хөгжил, цар тахлын хүнд үеийн тусламж дэмжлэг, цаашдын хамтын ажиллагааны хөгжил” илтгэлийг танилцуулсан.

Мэдээллийн технологийн чиглэлээр:

Аймгийн ЗДТГ-ын цаг үеийн 80 мэдээ, аймгийн Засаг даргын 5 мэндчилгээг бэлтгэж аймгийн сайт болон цахим хуудсанд байршуулсан.

“Цахим шилжилт” сэдэвт сургалтыг 09 сарын 16-ны өдөр агентлаг, сумдын мэдээллийн технологи хариуцсан ажилтнууд, албан хэргийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй нийт 100 гаруй албан хаагчийг хамруулан зохион байгуулсан.

“Мэдээлэл технологийн үндэсний парк”-тай хамтран 10-12 дугаар ангийн 25 хүүхдийг сонгон мэдээлэл технологийн чиглэлээр сургалт хийж, тэдгээр сурагчдын дунд “Хакатон” тэмцээнийг зохион байгуулсан.

Төрийн байгууллагуудад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, иргэдэд салбарын үйл ажиллагааны мэдээллийг албаны цахим хаягаар тогтмол хүргэж буй байдал болон дотоод үйл ажиллагаанд нэгдсэн систем нэвтрүүлсэн байдлыг үнэлэн, зөвлөн туслах замаар гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилгоор 09 дүгээр сарын 28-

30-ны өдрүүдэд хяналт, үнэлэлт хийх удирдамжийн дагуу 26 агентлагт хяналт шалгалт хийсэн.

ХОЁР: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС:

Тус хэлтсээс 2022 оны 09, 10 дугаар сард хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, түүний дагуу 9 дүгээр сард төлөвлөсөн ажлуудыг бүрэн зохион байгуулж ажиллалаа.

2022 оны 09 дүгээр сард хэвлэгдэн гарсан “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2 дугаарыг хүлээн авч, нийтлэгдсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг төрөл тус бүрээр нь нэг бүрчлэн бүртгэж лавлагаа мэдээллийн санд баяжуулалт хийж ажиллалаа.

Засгийн газрын 1111 төвөөс ирүүлсэн 3 өргөдлийг хүлээн авч судлан холбогдох ажиллагааг явуулж цаг хугацаанд нь хариуг хүргүүлсэн.

Өрсөлдөөний тухай хууль болон Монгол Улсын Шадар сайдаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2022 оны хамтран ажиллах гэрээнд заасны дагуу орон нутагт Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын чиг үүрэг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллах орон тооны ажилтанг томилж ажиллуулах асуудлын хүрээнд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн санал болон хамтран ажиллах гэрээний төслийг хүлээн авч судлан үзээд бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар холбогдох хариуг хүргүүлсэн.

320 хүүхдийн сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл удаашралтай байгаатай холбогдуулан улсын төсвийн хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг шалгуулах, мөн газрын дуудлага худалдаанд ялалт байгуулсан оролцогч газрын дуудлага худалдааны үнийг төлж газраа эзэмшихгүй, зохиомлоор үнийн хөөрөгдөл үүсгэж санаатайгаар амжилтгүй болгож байгаа эсэхийг тодруулахаар аймгийн Цагдаагийн газарт гомдол хүсэлт гаргасан.

Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн албан бичгийн дагуу Хөвсгөл сумын Засаг даргаар ажиллаж байсан Н.Энхбаярт холбогдох нотлох баримтуудыг гарган хугацаанд нь хүргүүлсэн.

Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд цахимаар оролцож иргэн И.д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Мөн Дорноговь аймаг дахь Прокурорын байгууллагын 90-н жилийн ой болон Ханги хилийн боомт байгуулагдсаны 20-н жилийн ойн арга хэмжээнүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран тус тус зохион байгуулж ажилласан.

Сайншанд сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар улиралд батлан гаргасан захирамжлалын баримт бичгүүдийг хянан үзэж холбогдох зөвлөгөө мэдээллийг өгсөн.

“Бүрэн Монгол” төслийн ажлын хэсгийг 2022.09.16-ны өдөр хүлээн авч, хамтран ажиллаж, төсөлд тус аймгаас сонгогдсон эх орныхоо алтан соёмбод тангараг өргөсөн иргэдийн амар тайван, аюулгүй байдлыг хангах албанд хоёргүй сэтгэлээр нэр төртэйгээр хүчин зүтгэж яваа залуу болох Дорноговь аймгийн Хатанбулаг сумын харьяат Цагдаагийн дэд ахлагч М.Мөнхсүрэнгийн гэр бүлд иж бүрэн тавилгатай өргөө цагаан гэрийг гардуулан өгсөн. Энэхүү төслийг орон нутгаас дэмжин ажиллахаа илэрхийлж уг гэр бүлд амьдрах хашааг газрын асуудалтай нь шийдвэрлэхээр болж, газрын батламжийг аймгийн Засаг дарга О.Батжаргал гардуулан өгснөөс гадна нийгэмд залуучуудын оролцоог бий болгох,

Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, Эв нэгдлийг цогцлоон бий болгох энэ үйлсэд үнэтэй хувь нэмрээ оруулж буй “БҮРЭН МОНГОЛ” төслийн баг хамт олонд талархал илэрхийлж хүндэтгэл үзүүлсэн.

2022.09.16-ны өдөр аймгийн шинэ Спорт цогцолборын гадна талбайд Хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах болон гомдол мэдээлэл, санал хүсэлтийг хүлээн авах ажлуудыг зохион байгуулснаас гадна гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 265 зурагт хуудас, 300 гаруй санамж сэрэмжлүүлгийг иргэдэд тараан өгч, 100 гаруй иргэдэд хууль, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн.

Мөн шүүхийн ил тод нээлттэй байдал болон шүүхэд нэхэмжлэл, өргөдөл, гомдол хэрхэн гаргах талаар 40 гаруй иргэнд арга зүйн зөвлөгөө, эрүү, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр 9 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Энэ үеэр Дорноговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсээс 51 иргэнд тоон гарын үсэг олгож, 78 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, шинээр батлагдан гарсан хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлын хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр агентлаг, сумдын мэдээллийн технологи хариуцсан болон албан хэргийн эрхлэгч нарын нийт 100 гаруй албан хаагчдад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар сургалт зохион байгуулж, мэдээлэл хариуцагч буюу төрийн байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг, тэдгээрийн зүгээс ил тод, нээлттэй байлгах мэдээлэл, нийтийн мэдээллийн дэд бүтэц зэрэг асуудлуудаар тус тус мэдээлэл хүргэсэн.

Төр, нийтийн эрх ашиг зөрчигдсөний улмаас үүссэн хохирол төлбөрийг шүүхээр шийдвэрлүүлэх, төлүүлэх ажлыг аймгийн Прокурорын газартай хамтарсан удирдамжийн дагуу зохион байгуулж энэ хүрээнд сумдын ЗДТГ, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудтай хамтран дараах ажлуудыг зохион байгуулж байна.

Үүнд:

1.Төрд учирсан хохирлын судалгааг нэгтгэж, хэрэг маргааны төрлөөр ангилан ялгасан.

2.Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлтэй холбоотой шүүхийн шийдвэр биелэгдээгүй асуудлууд нэлээдгүй байх тул аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах чиглэлийг хүргүүлсэн.

3.Сумдын Засаг дарга нарт шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх, шүүхийн шийдвэр биелэгдээгүй тохиолдол бүрт Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандан хүсэлт гаргуулан гүйцэтгэх хуудас бичүүлэх арга хэмжээ авч ажиллах чиглэлийг хүргүүлээд байна.

4.Прокурорын газартай хамтран Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангахад анхаарах асуудлаар нийт сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, холбогдох мэргэжилтнүүдэд мэдлэг олгох сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 09.00 цагт цахим хэлбэрээр

зохион байгуулж, цаашид энэхүү асуудалд онцгой анхаарч хамтран ажиллах үүрэг чиглэлийг өгсөн.

5.Аймгийн Прокурорын газраас Замын-Үүд сум дундын Прокурорын газартай хамтран төр, нийтийн эрх ашиг зөрчигдсөний улмаас үүссэн хохирол төлбөрийг буюу зарим сумдад холбогдох сум хөгжүүлэх сангийн зээлийн асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэхээр төрийн байгууллагаар хүсэлт, нэхэмжлэл гаргуулах, прокурор нэхэмжлэл бичих ажлыг зохион байгуулж байна.

6.Улсын төсвөөр баригдаад дутуу орхигдсон, тендер аваад ажлаа гүйцэтгээгүй компаниудтай холбоотой асуудлуудын судалгааг гаргаж эдгээртэй холбогдох баримт, материалуудыг цуглуулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

7.Мөн 11 суманд байгаа 56 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 3,520,403,775 төгрөгийн газрын төлбөр төлөгдөөгүй судалгааг гаргаж нэр бүхий сумдын Засаг дарга нарт үүрэг өгч газрын төлбөр төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудын хамтарсан уулзалтыг зохион байгуулах ажлыг төлөвлөөд байна.

Аймгийн зорилтот жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудын албан хэрэгцээнд ашиглагдах туулах чадвар сайтай автомашинуудын зардлыг шийдвэрлэсний дагуу 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр тус тус гардуулан өгч, үйл ажиллагаанд нь ашиглуулж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн (орон нутгийн) хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Сурагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажлын хүртээмжийг нэмэгдүүлэхэд сургуулийн нийгмийн ухааны багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг татан оролцуулах, тэдгээрийн бүтээлч санал санаачилгыг нь дэмжиж бодит ажил хэрэг болгох төсөл хэрэгжүүлэх удирдамжийг боловсруулан нийт сумдын ЗДТГ, аймгийн БШУГ-т тус тус хүргүүлээд байна. Төслийг 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч, сонгон шалгаруулж, 3 төсөлд 7,5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтран хэрэгжүүлнэ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Авлигын эсрэг тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдийн мэдээлэл хайх, хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, салбарын үйл ажиллагааны мэдээллийг албаны цахим хаягаар тогтмол хүргэж буй байдал болон дотоод үйл ажиллагаанд нэгдсэн систем нэвтрүүлсэн байдлын талаар үнэлгээ өгөх, зөвлөн туслах ажлын удирдамжийг боловсруулан аймгийн Засаг даргын захирамжаар батлуулж, 2022 оны 09 дүгээр сарын-27-29-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлагуудад хяналт шалгалт хийж, түүний мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулан ажиллаж байна.

“Ханбаянзүрх хайрхан уул, хамарын хийд орчмын тусгай хамгаалалттай газрын аялал жуулчлалын бүсэд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч, аялагчдын нийтээр дагаж мөрдөх журам”-ын төслийн боловсруулан цахим байршуулж иргэдээс санал авах ажиллагааг зохион байгуулж байна.

Мөн энэ ажлын хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зорилтот бүлгийн 40 гаруй иргэдэд, 09 дүгээр сарын 30-ны өдөр ажлын хэсгийн гишүүдийн уулзалт хэлэлцүүлгүүдийн тус тус зохион байгуулж, гарсан саналыг нэгтгэн журмын төсөлд тусган аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 8 дугаар сарын байдлаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, аймгийн Цагдаагийн газрын холбогдох төлөөллүүдтэй цаашид авах арга хэмжээний чиглэлийг тодорхойлж ажилласан бөгөөд энэ хүрээнд цахим залилах төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг 2,0 сая төгрөгийн санхүүжилтээр масс мессеж үйлчилгээгээг дамжуулан орон нутгийн 60,0 мянга гаруй иргэдэд хүргэлээ.

“Замын-Үүд боомтоор нэвтрэх ачаа тээврийг зохицуулах түр журам батлах тухай” аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/44 дүгээр захирамжийг хүчингүй болгож, шинээр үүссэн нөхцөл байдлын хүрээнд холбогдох байгууллагуудын чиг үүрэг, уялдаа холбоог хангаж Замын-Үүд боомтоор нэвтрэх ачаа тээврийн үйл ажиллагааг шинэ журмаар зохицуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг чиглэлийг Замын-үүд сумын Засаг даргад хүргүүлсэн.

Шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд туслах малчдын хөдөлмөрлөх эрхийг хангахтай холбоотой асуудлаар Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комиссын гишүүнээс зөвлөмжийн хүрээнд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон сумдын Засаг дарга нар ажлын чиглэл хүргүүлж, холбогдох мэдээллээр хангаж ажилласан.

Цагдаагийн газар:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Мөрдөн байцаах тасгаас аймгийн хэмжээнд гэмт хэргийн шийдвэрлэлтийг ахиулах зорилгоор "Шийдвэрлэлт" хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, үлдэгдэл 70 хэргээс 59 хэргийг шийдвэрлэж ажилласан.

Сайншанд суманд оршин суух хаягтай ахуйн хүрээндээ байнга архи дан согтуурч, ойр орчиндоо түгшүүр төрүүлдэг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж удаа дараа шүүхийн шийтгэвэрээр баривчлагдсан архины хамааралтай иргэдийн дунд “Албадан эмчилгээ” арга хэмжээг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд зохион байгуулахаар төлөвлөгөө гарган эрүүл мэндийн байгууллагын үзлэгт хамруулж, эрүүл мэндээр тэнцсэн 12 иргэнийг албадан эмчилгээнд хамруулсан.



Тус цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн алба хаагчид 2022 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Автотээврийн төвтэй хамтран “Өөрийгөө хайрлая” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, Замын цагдаагийн



тасагт хэрэглэгдэж байгаа тусгай хэрэгсэл, техник зэргийг сурталчлан ажилласан.

Мөн зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд 8 төрлийн 1000 ширхэг санамжийг тараан ажилласан.



Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв

журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас цагдаагийн алба хаагчдын ажиллах эрч хүчийг урам зоригийг нэмэгдүүлэх, ёс зүйтэй сахилга батыг сайжруулах, хууль эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх “Хандлага дор-Хүндлэл оршино” нөлөөлийн аян энэ оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс 45 хоногийн хугацаатай зохион байгуулагдаж байна. Арга хэмжээний хүрээнд “Инээмсэглэлийн өдөр”, “Уучлал хүсэх”, Мэдлэгээ хуваалцъя”, “Урам өгөх өдөр” зэрэг арга хэмжээнүүдийг шат дараатайгаар зохион байгуулж алба хаагчдын ар гэрт нь талархалын ил захидал гарын бэлэг гардуулан өгч ажилласан.

Улсын хэмжээнд 2022-2023 оны Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан “Хичээл эхэллээ-2022” арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж буй DTV телевизэд 1 удаагийн мэдээлэл өгч “Дорноговь цагдаа”, “Замын-Үүд цагдаа” фэйсбүүк хуудсанд мэдээллийг тухай бүрт түгээлт хийн ажилласан.

Хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан нээлтийн арга хэмжээний үед аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэгийн ойр орчимд нийтийн хэв журам сахиулах, замын хөдөлгөөнийг зохицуулах зорилгоор 135 цагдаагийн алба хаагчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэмэлтээр үүрэг гүйцэтгүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажилласан.





Сургуулийн орчинд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны газар болон Ерөнхий боловсролын сургуулиуд, Политехник коллежийн захирлуудтай "2022-2023 оны хичээлийн жилд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх гурвалсан гэрээ"-г байгуулж цаашид зохион байгуулах ажил арга хэмжээний талаар мэдээлэл солилцож ажиллалаа.

Цагдаагийн Ерөнхий газраас улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа "Илрүүлэлт оргодол 2022" нэгдсэн арга хэмжээ, тус цагдаагийн газраас зохион байгуулж байгаа "камер" хэсэгчилсэн арга хэмжээнүүдийн хүрээнд хэв журмын болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн хяналт шалгалтыг 2022 оны 09 дүгээр сарын 23-ны 20:00 цагаас 2022 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 02:00 цагийн хооронд нэгдсэн эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласан.

Улсын хэмжээнд зохион явуулж байгаа "Хичээл эхэллээ" ерөнхий арга хэмжээний хүрээнд оюутан, сурагч, хүүхэд багачуудыг гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Үе тэнгийн дээрэлхэлт" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:

Цагдан хорих байрны талаар:

Хоригдогч, хоригдлын дундаас гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэн ажиллаж үзлэг, нэгжлэгийг тогтмол хугацаанд чанартай зохион явуулан ажилласан.

Цагдан хорих байрны үйл ажиллагаа цагийн хуваарийн дагуу хэвийн явагдаж ямар нэг гэмт хэрэг, зөрчил дутагдалгүй байна.

Шийдвэр гүйцэтгэх тасгийн үйл ажиллагаа:

Шийдвэр гүйцэтгэх тасгийн хэмжээнд төлбөрийн 336 гүйцэтгэх баримт бичиг, хүүхдийн тэтгэлэгийн 272 гүйцэтгэх баримт бичиг нийт 608 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан талаар: Шийдвэр гүйцэтгэгч нар өнгөрсөн ажлын өдрүүдэд 11 төлбөр, тэтгэлэг төлөгчийн хаягаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 37 төлбөр тэтгэлэг төлөгчид шүүхийн шийдвэр биелүүлэх хугацаатай мэдэгдэл гардуулж, 30 төлбөр төлөгчийг дуудан уулзаж, 11 төлбөр төлөгч иргэн хуулийн этгээдийн арилжааны банк дахь дансыг битүүмжилсэн, 2 төлбөр төлөгчийн цалин хөдөлмөрийн хөлснөөс суутгал суутгах тогтоолыг ажил олгогчид хүргүүлсэн.

Шүүхээс эрүүгийн 4, зөрчлийн 1, хүүхдийн тэтгэлэгийн 2, иргэний шүүхийн шийдвэртэй 2 гүйцэтгэх баримт бичиг нийт 9 гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч харьяалах тойргийн шийдвэр гүйцэтгэгч хүлээн авч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлсэн.

Энэ 7 хоногт төлбөрийн 1 хүүхдийн тэтгэлэгийн 4 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгосон байна.

Тус газрын төлбөрийн харилцах дансаар: 2022.09.23-2022.09.30-ны өдрүүдэд шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар 23.670.827 төгрөгийг төвлөрүүлж ажилласан бөгөөд 3.030.336 төгрөгийг төлбөр тэтгэлэг авагчид олгож ажилласан байна.

Улсын бүртгэлийн хэлтэс:

- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр- 986
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр- 133
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр- 412

Нийт 1115 бүртгэл хөтөлж, үйлчилгээ үзүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь энэ сард нийт 412 мэдүүлэг хүлээн авч зохих үйлчилгээг үзүүлж, үйлчилгээний хураамж 4444677 төгрөг, тэмдэгтийн хураамж 172015 төгрөг, Үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны татварт 31330150 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

ГУРАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС

Хэлтэст энэ сард нийт 102 бичиг ирж, хариутай 68 бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, бусад 24 албан бичиг нь мэдээлэлд авах болон цаашид авч хэрэгжүүлэх тухай байсан. Засаг даргын захирамж 21 батлагдсан.

Хөрөнгө оруулалтын ажлын чиглэлээр:

1. Худалдан авах ажиллагааны талаар:

Энэ сард 6 тендерийг нээж үнэлэн, шалгарсан аж ахуй нэгжүүдэд мэдэгдэл албан бичиг хүргүүлж, ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.

Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын хугацаагүй эрх олгох сургалтыг ОНӨГазар зохион байгуулсан. Сургалтад аймгийн хэмжээнд нийт 143 хүн хамрагдаж 76 хүн шалгалтад тэнцэж хугацаагүй эрхээ авсан.

Энэ онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 59, Замын сангаар 5, ОНХСангаар 4, Их засварын хөрөнгө оруулалтаар 8 ажил нийт 86 төсөл арга хэмжээ хийгдэхээр батлагдсан. Үүнээс 81 төсөл арга хэмжээний тендерийг зарласанаас үйл ажиллагаа гүйцэтгэж дууссан 26, үйл ажиллагаа явагдаж байгаа 52, тендер нээх хугацаа болоогүй 3, тендер зарлагдаагүй 6 ажил байна. Нийт батлагдсан төсөл арга хэмжээний тендерийн зохион байгуулалт 94 хувийн гүйцэтгэлтэй байна.

2. Санхүүжилтийн талаар:

Улсын төсвийн 2 ажлын 1,4 тэрбум төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалтын 14 ажлын гүйцэтгэлд 2,4 тэрбум төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 3 ажлын гүйцэтгэлд 165,5 сая төгрөг, нийт 19 ажлын 4,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрхийг тус тус нээсэн.

3. Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл явцын талаар:

Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын дууссан 8 ажилд улсын комисс ажиллуулах хүсэлт ирсэний дагуу ГХБХГазартай хамтран 4 ажлыг хүлээн авч, 5 ажилд хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хийгдэх төсөл арга хэмжээний саналыг хэлэлцэх хэлэлцүүлгийг сумдын Засаг дарга нартай цахимаар 10 дугаар сарын 03-ны өдөр хуралдахаар хөтөлбөр боловсруулсан .

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил 60 орчим хувьтай үргэлжилж байна.

2022.09.16,17-ны өдрүүдэд “Намрын ногоо өдрүүд” арга хэмжээг зохион байгуулж орон нутгийн газар тариалан, хүнс, баялаг бүтээгчдийн үйл ажиллагааг сурталчилан борлуулалт хийсэн.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх чиглэлийг сумд, холбогдох агентлагуудад хүргүүлсэн.

Нийслэл дэх анхан шатны шүүхэд “Дөрвөн талст эрдэнэ” ХХК-тай холбоотой баримт материалыг хүргүүлсэн

Хөвсгөл цаг уурын станцын цахилгааны хүчдэлийг нэмэгдүүлэхэд 2,3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Замын-Үүд боомтын өргөтгөл шинэчлэлттэй холбоотой түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрлийг “УБТЗ”- д олгосон.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд “Яндангаа хөөлье-Өнөтэй өвөлжье” аяны явцын тайлан хүргүүлсэн.

АЗДТГ-ыг 70521111 утсанд ирүүлсэн 1 өргөдлийн хариуг хүргүүлсэн

Дэд бүтцийн чиглэлээр

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хамарын хийдийн 29-31 дэх км авто замын нөхөөс хийх ажил, Шинэ халдвартын эмнэлгийн зогсоол, 33 дугаар байрны зогсоол, 2 дугаар сургуулийн арын замыг офицерийн төв замтай холбох 0,577 км авто зам шинээр хийх ажил, 2 дугаар сургуулийн арын замыг хучилт хийх зэрэг 5 ажилд 09 дүгээр сарын 21-ны өдөр улсын комисс ажилласан. 33 дугаар байрны зогсоол, 2 дугаар сургуулийн арын замыг хучилт хийх ажлыг хүлээн авч бусад ажилд үүрэг даалгавар өгсөн. Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаварыг 14 хоногын хугацаанд биелүүлж улсын комиссд хүлээж авахаар ажиллаж байна.

ОСНААГ-ыг судлаж байгуулахаар аймгийн Засаг даргын орлогч Г.Март-аар ахлуулсан ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн анхны хурлыг 10 дугаар сарын 03-ны өдөр хуралдуулахаар тов зарласан.

Аймгийн Засаг даргын А/388 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулахаар Замын-Үүд Дулааны станц ТӨҮГ, Чандмань-Илч ОНӨХХК, сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн боловч Сайншанд сумын Засаг даргаас бусад агентлаг, засаг дарга нар хариу ирүүлээгүй байна.

Засгийн газрын өргөдөл, гомдол хүлээж авах 11-11 төвд Замын-Үүд сумын ачаа тээвэртэй холбоотой 1 иргэний гомдол ирснийг судалж хариу өгсөн.

Орон нутгийн чанартай авто замын маршрут батлуулахаар 1 ААН хүсэлт ирүүлснийг судалж байна.

Барилга, хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт “Бүс нутгийн логиستيкийн төвийг хөгжүүлэх” төслийн хүрээнд Засгийн газрын 2019 оны 155 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан 400 га газрын “Улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах гэрээ”-ний төсөлтэй танилцаж, холбогдох саналыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлсэн. Дорноговь аймагт орчин цагийн барилгын салбар үүсэж хөгжсөний түүхт 60 жилийн ойн баярын хурлыг 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр “Саран хөхөө” театрт зохион байгуулж, ахмад барилгачид, барилгын салбарын ажилчин албан хаагч 300 гаруй хүмүүс оролцсон. Баярын хурлын үеэр Монгол Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан, Төмөртоогогийн Энхтүвшин, аймгийн Засаг дарга Очирхүүгийн Батжаргал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Батцэнгэлийн Ганзориг нар баярын мэндчилгээ дэвшүүлж, аймгийн Барилгачдын

холбооны тэргүүн асан Будын Энхтайван Дорноговь аймгийн Барилгын салбарын түүхэн замналын талаар илтгэл тавьсан.

Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын гишүүд Иххэт сумын өвс тэжээлийн агуулах, Алтанширээ сумын эрүүл мэндийн төвийн засварын ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь танилцаж, холбогдох үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт, хурлын тэмдэглэл 4 ажил дээр гаргаж баталгаажуулсан. (Зүүнбаян соёлын төвийн засвар, Иххэт өвс тэжээлийг агуулах, Сайншанд сумын 2 болон 4 дүгээр цэцэрлэгийн засвар)

Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх 4 хүсэлтийг хянаж зөвшөөрөл олгосон.

Аймгийн хэмжээнд 9 дүгээр сард нийт 25 газрын дуудлага худалдаа зохион байгуулсан. Үүнээс дуудлага худалдааны 226,1 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Хүлээгдэж байгаа орлого 253,8 сая төгрөг.

Газар өмчлөх, эзэмших эрх шилжүүлэх, газар эзэмших эрх дуусгавар болгохоор ирүүлсэн 6 хүсэлтийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.

Аймгийн хэмжээнд Монгол улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын байршил, хэмжээний саналыг авч нэгтгэн хянаж, аймгийн ИТХ-д өргөн барихад бэлэн болгосон.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний хүрээнд аймгийн прокурорын газар, саран хөхөө театрийн эрэгтэй албан хаагчдад “Эрчүүдийн эрүүл мэнд” сэдвээр танхимын сургалт, БШУГ-ын эрэгтэй ажилчидад цахим сургалт оров. Сургалтанд нийт 81 хүн хамрагдав.
- Ахмадын эрүүл мэндтэй холбоотойгоор “Ахмадын эрүүл мэнд” сэдэвт нэг удаагийн танхимын сургалтын удирдамжийг батлуулж, аймгийн ахмадын холбоотой хамтран сургалт оров. Сургалтаар артерийн даралт ихсэлт, стресс, үе мөчний өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдээлэл болон эрт илрүүлэг, коронавирүсийн халдварын өнөөгийн байдлын талаар мэдээллийг хүргэв.
- Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/414 дүгээр тушаалаар коронавирүст халдвар /КОВИД-19/-ын тандалт, хариу арга хэмжээнд шаардлагатай 150.1 сая төгрөгийн 4 төрлийн хамгаалах хувцас хэрэгсэл хуваарилсныг татан авч, 23 эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгосон.
- Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/430 дугаар тушаалаар дархлаажуулалтанд шаардлагатай 5.9 сая төгрөгийн аюулгүйн хайрцгийг татан авч, 19 дархлаажуулалтын нэгжүүдэд хуваарилан олгосон.
- Иргэдийн буруу үйлдэл, дадал зуршлийг өөрчлөх, стандарт жорлонтой болох, хуванцар савны хэрэглээг багасгах, орчны эрүүл ахуйг сайжруулах зорилгоор “Зөв хөрш” аян эхлүүлсэн.

- Эрүүл мэндийн газрын даргын “Гэр сувилал ажиллуулах тухай” 2017 оны А/65 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 687 тоот албан бичгийг ЭМБ-дуу хүргүүлсэн. Бага насны хүүхдүүдийг байгалийн аргаар эмчлэх, чийрэгжүүлэх, аминдэмжүүлэх, эцэг эхийн хүүхдээ асрах сувилах мэдлэгийг дээшлүүлэх замаар суурь болон цочмог өвчлөл, эрдэс аминдэмийн дутлыг бууруулах зорилгоор 06-60 сар хүртэлх зорилтот бүлгийн 253 хүүхдийг 2022 оны 06 дугаар сарын 15-наас 08 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд 14 эрүүл мэндийн байгууллага нийт 17 ээлжээр гэр сувилалыг ажиллуулж нийт 12.368.205 ₮ зарцуулсан байна. Мөн сувилалд хамрагдсан хүүхдүүдийн эцэг эхчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж, 66 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 958 хүнийг хамруулж бага насны хүүхдийн асаргаа сувилгаа, нэмэгдэл хооллолт, мэдлэгийг дээшлүүлсэн. Сувиллын хугацаанд хүүхдүүдийн хоолны дуршил сайжирч, биеийн жин 100гр-1100гр нэмэгдэж, бугалганы тойрог 0,5 мм-2см нэмэгдсэн үр дүнтэй ажиллаа.
- “УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ ОНОШИЛГОО”-нд 2022 оны 05 сарын 01-нээс 09 сарын 08-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 14.8% буюу 10655 иргэд хамрагдсан. Үүнээс 81.7% /8707/-ийг 0-17 насны хүүхэд, 18.3% /1948/-ийг 18-аас дээш насны хүн ам эзэлж байна.
- Сүүлийн 7 хоногт / 09 сарын 05-наас 09 сарын 08 / сум, өрхийн ЭМТ-үүд 0-17 насны 54 хүүхэд, лавлагаа шатлалд 18-аас дээш насны 195 хүн нийт 249 урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрууллаа.
- “Урьдчилан сэргийлэх үзлэгийг эрчимжүүлэх” 3 сарын аянг 08 дугаар сарын 23-аас 11 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулаж байна. Аяны хугацаанд нийт 997 хүүхэд нийт буюу нийт хамрагдвал зохих хүүхдийн 3.9 хувийг хамруулсан байна. Аяны хугацаанд нийт хамрагдвал зохих 0-5 насны хүүхдийн 12.0 /942/ хувь, 6-17 насны хүүхдийн 0.2 /62/ хувийг хамруулсан байна.
- Сайншанд сумын ӨЭМТ-үүдтэй хамтран “Эрүүл шүдтэй анги хамт олон болзолт уралдаан”-д оролцож буй 15 анги, бүлгүүдэд явцын дэмжлэгт хяналт хийж арга зүйн зөвлөгөөг өглөө.
- Дорноговь аймгийн БОАЖ Газар, Сайншанд сумын багийн дарга нар болон иргэдэд “Орчны эрүүл ахуй” сэдвийн хүрээнд хөрс, ус, агаарын бохирдол, хог хаягдал, угаарын хийн хордлогын талаар сургалт зохион байгуулж мэдээлэл өглөө.
- “УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ ОНОШИЛГОО”-нд 2022 оны 05 сарын 01-нээс 09 сарын 21-ний өдрийн байдлаар аймгийн хэмжээнд хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 15.4% буюу 11113 иргэд хамрагдсан. Үүнээс 80.9% /8986/-ийг 0-17 насны хүүхэд, 19.1% /2127/-ийг 18-аас дээш насны хүн ам эзэлж байна.
- Сүүлийн 7 хоногт сум, өрхийн ЭМТ-үүд 0-17 насны 281 хүүхэд, лавлагаа шатлалд 18-аас дээш насны 179 хүн нийт 460 урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрууллаа.
- “Урьдчилан сэргийлэх үзлэгийг эрчимжүүлэх” 3 сарын аянг 08 дугаар сарын 23-аас 11 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулаж байна. Аяны хугацаанд нийт 1278 хүүхэд нийт буюу нийт хамрагдвал зохих хүүхдийн

5.1 хувийг хамруулсан байна. Аяны хугацаанд нийт хамрагдвал зохих 0-5 насны хүүхдийн 15.2 /1192/ хувь, 6-17 насны хүүхдийн 0.5 /93/ хувийг хамруулсан байна.

- Хавдар судлалын үндэсний төвийн нарийн мэргэжлийн 7 эмчийн бүрэлдэхүүнтэй баг 2022 оны 09 сарын бнаас 3 хоног ажиллаж, 1045 үзлэг хийж, хавдар-9 , сэжигтэй тохиолдол 70 илрүүлэн, 9-биопсийн шинжилгээ, 97-цитологи шинжилгээ хийж , ХСҮТ-рүү 18 хүнийг илгээсэн байна.
- Даланжаргалан, Алтанширээ сумын эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, бүрдүүлэх материалыг хянаж засуулав. Магадлан итгэмжлэлийн цахим программд 3 ЭМБ-ын тайлан, материалыг хянаж баталгаажуулав.
- ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛЭЛТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭ” сэвэдт 1,5 багц цагийн сургалтыг ХСҮТ-ийн эмч нартай хамтран зохион байгуулж нийт 64 эмч мэргэжилтэнг хамруулсан.
- "Эрүүл мэндийн салбар-Иргэдээ сонсоё" уулзалт хэлэлцүүлгийг 2022/09 сарын 20ны өдөр Сайншанд сумын 1,2,3,6,8 баг, 21-ний өдөр 4,7 багийн иргэдийн дунд амжилттай зохион байгууллаа. Уг уулзалтанд эрүүл мэндийн газрын удирдлагууд, нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн дарга нар оролцож, эрүүл мэндийн салбарын сүүлийн үеийн бодлого шийдвэрийн талаар мэдээлэл хийн, иргэдийн асууланд хариулт өгч, санал хүсэлтийн сонсон, сэтгэл ханамжийн судалгаа авч, иргэдийн санал хүсэлтийг цаашдын үйл ажиллагаандаа тусган ажиллахаар болов. Уг хэлэлцүүлэгт нийт 200 гаруй иргэд оролцож 13 иргэн асуулт асууж, 120 гаруй иргэн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан байна.
- ЭМГ-ын даргын батлагдсан удирдамжийн дагуу 5 хүний брэлдэхүүнтэй ажлын хэсэг Даланжаргалан, Алтанширээ сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа болон магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажилтай танилцан, шалгуурын дагуу үнэлгээ хийж, зөвлөмж өгч, алдаа дутагдлыг газар дээр нь засуулж, мэргэжил арга зүйгээр хангалаа.
- "Эрүүл мэндийн салбар-Иргэдээ сонсьё" уулзалт хэлэлцүүлгийг 2022/09 сарын 20ны өдөр Сайншанд сумын 1,2,3,6,8 баг, 21-ний өдөр 4,7 багийн иргэдийн дунд амжилттай зохион байгууллаа. Уг уулзалтанд эрүүл мэндийн газрын удирдлагууд, нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн дарга нар оролцож, эрүүл мэндийн салбарын сүүлийн үеийн бодлого шийдвэрийн талаар мэдээлэл хийн, иргэдийн асууланд хариулт өгч, санал хүсэлтийн сонсон, сэтгэл ханамжийн судалгаа авч, иргэдийн санал хүсэлтийг цаашдын үйл ажиллагаандаа тусган ажиллахаар болов. Уг хэлэлцүүлэгт нийт 200 гаруй иргэд оролцож 13 иргэн асуулт асууж, 120 гаруй иргэн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан байна.
- ЭМГ-ын даргын батлагдсан удирдамжийн дагуу 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Даланжаргалан, Алтанширээ сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа болон магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажилтай танилцан, шалгуурын дагуу үнэлгээ хийж, зөвлөмж өгч, алдаа дутагдлыг газар дээр нь засуулж, мэргэжил арга зүйгээр хангалаа.
- АШУҮИС-ийн салбар Дорноговь аймаг дахь Анагаах Ухааны сургуулийн түүхт 60 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэв.

- Улсын болон орон нутгийн төсвийн 657 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр хүлээн авах ёслолын арга хэмжээг зохион байгууллаа. Уг үйлдвэр ашиглалтад орсноор аймгийн Нэгдсэн эмнэлэг төдийгүй сумын Эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн эмнэлгүүдийг хүчилтөрөгчөөр бүрэн хангах хүчин чадалтай юм.

СОЁЛ УРЛАГ, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого зохион байгуулах ажлын хэсэг энэ 7 хоногт Сайхандулаан, Мандах сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэх, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж ажиллав.
- “Саран Хөхөө” театрын дэргэдэх “Авьяас” хүүхдийн дугуйлан 7 хоногийн 2,4 дэх өдрүүдэд тогтмол хичээллэж байна.
- Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Музей сургалт судалгааны төв, МУЭ-ийн Дорноговь аймгийн салбар хамтран “БАГШ-2022” хамтарсан үзэсгэлэнг дэлгэлээ. Үзэсгэлэнд Монголын урчуудын эвлэлийн Дорноговь аймгийн салбарын зураач, урчуудын 30 бүтээл дэлгэгдсэн ба үзэсгэлэн 10 дугаар сарын 07-ныг хүртэл үргэлжилнэ.
- Багш нарын баярыг угтсан “Бүтээн байгуулалт” үзэсгэлэнг Саранхөхөө театрт зохион байгуулав.
- Цэцэрлэгүүдийн туслах багш нарын дунд “Үлгэрч багш” уралдааны талаар 5 удаа зөвлөгөө мэдээлэл хүргэсэн бөгөөд хүүхэд багачуудын уншвал зохих номыг болон сэдэвчилсэн 50 номоор үзэсгэлэн гаргасан.
- МУСГЗ яруу найрагч А.Эрдэнэ-Очирын “Шүлгийг хэн цээжээр сайн унших вэ?” уралдааныг шалгаруулж шилдэгийг тодруулсан. Монголын бүх ард түмний спортын XV наадмын анхан шатны тэмцээн гуравдугаар сараас гурван үе шаттайгаар орон даяар өрнөсөн бол шигшээ тэмцээн есдүгээр сарын 9-нөөс эхлэн спортын 26 төрөл (олимпын 18, оюун ухааны хоёр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зургаа)-д болов.
- Монголын бүх ард түмний спортын наадам нь иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэх, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, олимпын багуудыг бүрдүүлэх онцгой ач холбогдолтой юм. Энэхүү наадмын анхдугаар тэмцээнийг 1961 онд Ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж, өвөл, зуны спортын 17 төрлөөр зохион байгуулж байв. Анхдугаар наадамд 130 мянга гаруй тамирчин оролцсоноос 1134 тамирчин спортын зэрэг цолыг биелүүлж, улсын дээд амжилт 29 удаа шинэчлэн тогтоож байжээ. Тэрхүү наадмын нэгдсэн дүнг “Алдар” спорт хороо, “Булган” нийгэмлэгүүд тэргүүлж байсан байна. Энэ наадам дөрвөн жил тутамд зохион байгуулагддаг бөгөөд XV наадамд 21 аймаг, есөн дүүргээс шалгарсан 4500 гаруй тамирчин 561 багц медалийн төлөө өрсөлдсөнөөс Дорноговь аймгийн баг тамирчид спортын 13 төрлөөр 118 тамирчин оролцож 1 алт, 5 мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн амжилттайгаар оролцлоо. Үүнд:
 1. Алтан медаль-1
 - Сайхандулаан сумын харъяат Чинболдын Отгонтуяа чөлөөт бөхийн 53 кг жинд алтан медаль авсан.
 2. Мөнгөн медаль -5
 - Дашийн Чингис боксын -81 кг-ийн жинд мөнгөн медаль
 - Пауэрлифтингийн 66 кг-д Эрдэнэболдын Нанзаддорж мөнгөн медаль,

- Хурдан буудлагын төрөлд Лхагвын Ундралбат мөнгөн медаль,
- Батбаярын Баттөгс паражүдо бөхийн -90 кг жингийн мөнгөн медаль
- Батсүхийн Хашцэцэг паражүдо бөхийн +70 кг-ийн жинд мөнгөн медаль

3. Хүрэл медаль -3

- Таэквондогийн 57 кг-ийн жинд Э.Алтантуяа хүрэл медаль
- Болормаагийн Ууганхүү паражүдо бөхийн -73 кг-ийн жинд хүрэл медаль
- Нямсүрэнгийн Ганбат паражүдо бөхийн +90 кг-ийн жинд хүрэл медаль тус

тус хүртлээ.

- Соёл, урлагийн ажилтны өдрийг жил бүр болдог уламжлалтай. Энэхүү тэмдэглэлт өдрөөр аймгийн соёл, урлагийн салбарын ажилтны спортын арга хэмжээ 09 дүгээр сарын 08-ны өдөр Спорт цогцолборт боллоо.

- Монголын Хөлбөмбөгийн Холбоо, Дорноговь аймгийн Хөлбөмбөгийн холбоо хамтран “Грассрүүтс болон өсвөрийн хөлбөмбөг” хөтөлбөрийн сургалтыг 09 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд аймгийн хэмжээний ЕБ-ын сургуулиудын биеийн тамирын багш нарт явууллаа. Энэхүү сургалт нь Биеийн тамир, спортын газрын Спорт цогцолборын сургалтын танхимд боллоо.

- Хууль сахиулах байгууллагуудын дундах Спортын олон төрөлт тэмцээн 09 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд Спорт цогцолборт болов.

- Улаанбаатар Төмөр Замын Дохиолол холбооны албаны XXI спартакиад 2022 оны 09 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Спорт цогцолборт болж өндөрлөлөө.

- Цэнгэлдэх хүрээлэнд 09 дүгээр сарын 17-ны өдөр ЕБ-ын 5-р сургуулийн спартакиад, 09 дүгээр сарын 18-ны өдөр Дорноговь Политехник коллежийн спартакиад тус тус боллоо.

- Спортын ордонд 09 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Сайншанд татах хэсгийн спортын арга хэмжээ болов.

- Монгол Улсын өсөх идэр, улам нэмэх харцага Алтанбаганын Цацабширын нэрэмжит Үндэсний бөхийн өсвөрийн барилдаан 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр Спорт цогцолборт амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд 6 насны 150 гаруй хүүхэд оролцлоо.

- АШУҮИС-ийн харьяа Дорноговь аймаг дахь салбар сургуулийн 60 жилийн ойг угтсан спортын арга хэмжээ Спорт цогцолборт 09 дүгээр сарын 23-ны өдөр боллоо.

- Спортын ордонд 09 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд ахмадын Софт волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээн амжилттай болж өндөрлөв.

- Цэнгэлдэх хүрээлэнд 09 дүгээр сарын 24-ний өдөр ЕБ-ын 3-р сургуулийн спартакиад, 09 дүгээр сарын 25-ны өдөр ЕБ-ын 1-р сургуулийн спартакиад тус тус болов.

- Дорноговь аймгийн МАН-ын хорооноос зохион байгуулж буй “Эв нэгдлийн цом” спортын арга хэмжээ 09 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд Спорт цогцолборт боллоо.

- “Нөхөрлөл лиг” сагсан бөмбөгийн тэмцээн 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн үргэлжлэн явагдаж эхэллээ. Уг тэмцээн нь 7 хоног бүрийн Мягмар гарагт болж байна.

- Монгол Улсын Гарамгай мэргэн З.Баясгалангийн нэрэмжит шагайн харвааны тэмцээн Спорт цогцолборт 10 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд болж өндөрлөлөө.

- Багш нарын өдрийг тохиолдуулан аймгийн хэмжээний ЕБ-ын сургуулиудын Биеийн тамирын багш нарын уулзалт Спорт цогцолборт 10 дугаар сарын 01-ний өдөр болов.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Ахмадын өдрийг тохиолдуулан 09 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, Т.Энхтүвшин нар 75 хүртэлх насны ахмадуудад хүндэтгэл үзүүлэх ёслолийг зохион байгуулсан.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг аймгийн эрүүл мэндийн салбарт зохион байгуулах ажлын хэсэг Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд сумдын эрүүл мэндийн салбарт хяналт шалгалтыг 9 сарын 12-16-ний өдрийн хооронд зохион байгуулсан. Үзлэг шалгалт Айраг, Даланжаргалан, Сайншанд сум болон бусад сумдад үргэлжлэн явагдаж байна.
- ХБХЭМБНХСалбар комиссын 3 дугаар улирлын тайланг боловсруулан комиссын даргаар хянуулж ХНХЯамны төв комисст файлаар болон цаасаар хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд 09 дүгээр сарын байдлаар 251 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.
- Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд зохион байгуулагдаж байгаа залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн 4-р ээлжийн сургалтад хамрагдсан залуучуудын сургалт дууссан тул залуучуудтай уулзаж 14 хоногийн дадлагын талаар мэдээлэл өгч, дадлагын ажлыг эхлүүлээд байна. Төсөлд 33 залуучууд оролцсоноос дадлагад 30 залуу гарахаар мэдэгдснээс 2 залуу албан ёсоор дадлагаа эхлүүлээд байна.
- Мөн 1-3 дугаар ээлжинд хамрагдсан залуучуудын дадлагын ажлын тайланг хүргүүлэх, урамшууллыг олгуулах ажил үргэлжилж байна. Тэдгээрээс тайлант хугацаанд 2 оролцогчийн дадлагын дэвтэр бүрэн бөглөгдөж ерөнхий газарт ирэх долоо хоногийн 2 дахь өдөр шуудангаар илгээхээр хүлээгдэж байна.
- МУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа NEXTGEN төсөлд Дорноговь аймгаас 16 баг оролцож байгаа ба багуудын үйл ажиллагаанд тухай бүр чиглэл өгч ажиллаж байна.
- Дорноговь ХБХЭМБНХСКомиссын ээлжит хурлаар асаргааг сунгасан 23, шинээр 2, цуцалсан 1 нийт 26 хүүхдийн асуудлыг авч хэлэлцэж шийдвэрлэсэн.
- Сайншанд сумын ЕБС-ийн 1 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчдад Залуучууд хөгжлийн төвөөс зарласан арга хэмжээ, төсөл хөтөлбөр болон мэргэжил сонголтын мэдээллийг хүргэсэн.
- “Нэг хамт олон – нэг сайн дурын ажил” сайн үйлсийн аяныг идэвхжүүлж 14 сум болон ААНБ-уудад зөвлөгөө, чиглэл өгсөн. Одоогийн байдлаар 5 хамт олон уг аянд нэгдсэн байна.
- Хүүхдийн тусламжийн 108 утсанд 10 дуудлага мэдээлэл ирсэн. Харьяа хамтарсан багт шилжүүлэн хяналт тавьж ажиллаж байна. Үүнээс 1 кейсийг бүрэн ажиллагаа явуулж шийдвэрлэж хаасан.

- Сайншанд сумын хэмжээнд “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”-г зохион байгуулж ажилласан. Хууль эрх зүйн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтийг мэдлэгжүүлэх хүрээнд 178 эцэг эх, асран хамгаалагчид “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалт, 10-12 ангийн 290 сурагчдад “Авах гээхийн ухаан” лекцийг зохион байгуулсан.
- Хүчирхийлэлд өртсөн болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, холбон зуучлах арга хэмжээний хүрээнд 80 өрхөөр гэрийн эргэлт хийж сургууль завсардсан 5, цэцэрлэгт хамрагдаж чадаагүй 2, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 40 өрхийн 68 хүүхдийг илрүүлж, өрхөд хүнс, амин дэм, бичиг хэрэг, ахуйн хэрэглээний багцыг олгож хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг хүргэж ажилласан. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ арга хэмжээнд нийт 2536,1 мянган төгрөгийг зарцуулсан.
- Замын-Үүд суманд: “Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх” чиглэлээр Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль дээр “Хүүхдээ сонсьё” арга хэмжээг цагдаагийн хэлтсийн хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Н.Чулуунбат, сэтгэл зүйч Н.Сүхбат нарын хамт зохион байгуулан хамтарч ажиллалаа. Хүүхдүүдэд “Хүмүүжил гэж юу вэ”, “Сургуулийн орчин дахь дээрэлхэлт гэж юу вэ”, “Хүүхдийн эрх үүрэг” сэдвүүдээр сургалт орж харилцан ярилцсан. Мөн “Би гэр бүлдээ хайртай” зохион бичлэгийн уралдааныг зарласан 120 хүүхэд оролцож 4 бүлгийн 4 хүүхдийг шалгаруулж гарын бэлэг бэлэглэн урамшуулсан. Хүүхдүүдийн сэтгэгдэлийг сонсож, санал асуулгийн хуудсаар саналыг нь авч ажиллалаа.
- Цагдаагийн газарт 3 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажилласан. Утсан холбоогоор 1, биечлэн 1 иргэнд тус тус хууль зүйн зөвлөгөө өгсөн. Шүүхээс хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 1 насанд хүрээгүй этгээдэд 2 цагийн сургалт зохион байгуулж, нийтэд тустай ял шийтгүүлсэн 1 этгээдийг 12 цагийн ажил хийлгэн, 2 цагийн сургалтанд хамруулсан.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Ерөнхий ахлах болон мэргэжлийн, их дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын цахим сургалтын бэлэн байдлыг тандах судалгааг цахимаар авах тул ахлах ангид хичээл заадаг багш нарыг судалгаанд хамруулж байна. Мэдээллийг ЕБС-ийн удирдлагуудад хүргэн хамтран ажиллаж байна.

- ЕБС, СӨБ ийн удирдлагуудтай цаг үеийн асуудал, хичээл сургалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар цахим уулзалт зохион байгуулж 57 удирдлага хамрагдлаа.

- Багш мэргэжлээр төгсч ажлын байр хайж бүртгүүлсэн нийт 84 иргэнээс 9 сарын 16-ны байдлаар 59 иргэнийг ажлын байранд томилсон.

- 2022 оны 09 дүгээр сарын 19-21-ний хооронд БШУЯ, БЕГ, БҮТ-өөс үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан “ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ” сургалтад цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, Заах аргын нэгдлийн ахлагч нар хамрагдаж мэдлэг мэдээллээ нэмэгдүүллээ.

- Багшийн хөгжлийг дэмжих зорилгоор БЕГ-с зохион байгуулж буй Англи хэлний багш нарын 5 жилийн үндсэн сургалт 9 сарын 20-нд цахим сургалтаар эхэллээ.

- Багшийн хөгжлийг дэмжих зорилгоор БЕГ-аас зохион байгуулж буй цэцэрлэгийн багш нарын 5 жилийн үндсэн сургалт 2022.09.19-10.07-ыг хүртэл esurgalt платформын онлайн сургалтад хамрагдаж байна.

- БШУЯ, БЕГ, БҮТ-өөс үндэсний хэмжээнд зохион байгуулаж буй “Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх ” судалгааны ажлын явцтай танилцаж мониторинг хийх ажлаар БШУЯ-ны СӨБ хариуцсан мэргэжилтэн Б. Гантөгстэй хамтран Замын-Үүд сумын ЕБ-ын 1,2,3- дугаар сургууль, СШ сумын 2 ба 5 дугаар сургуулиудад ажиллалаа.

Сайншанд сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн үүсгэн байгуулагдсаны 50 жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

Зорилтод арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явц:

- 2022 оны 09-р сард орон нутгийн төсөвт 54.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс орон нутгийн төсөвт 34,5 тэрбум төгрөгийн орлого төвлөрч төлөвлөгөө 63,9 %-ийн биелэлттэй байна.
- Шилэн дансны хуулийн дагуу shilendans.gov.mn сайтад сар бүрийн 8-ний дотор нийт 146 байгууллагын мэдээлэлд хяналт хийж хугацаанд нь бүрэн оруулсан. Нийт төсөв хөрөнгөтэй холбоотой 20 захирамж байршуулсан.
- Орон нутгийн байгууллагад 600 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- Улсын төсвийн байгууллагын байр ашиглалтын зардалд 1,1 тэрбум санхүүжилт олгосон.
- Номин даатгал болон Монгол даатгалын компаниудын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар иргэдээс аймгийн Засаг даргын Тамгын газарт хандан өргөдөл, гомдол ирсэнийг санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, Зохицуулалтын газарт албан бичиг хүргүүлсэн.
- Нэмэлт санхүүжилтийн 48 байгууллагын хүсэлтийг үндэслэн 700 сая төгрөгийн хүсэлтийг үндэслэн нэмэлт төсвийн зарцуулах эрхийг нээж ажилласан.
- Хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийн Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 2022 оны 09 сарын 1-30-ний хооронд нийт 1877 гүйлгээний 13890.7 сая төгрөгийн төлбөр тооцоог Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд бүртгэснийг төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн шаардлагатай тохиолдолд анхан шатны баримтын бүрдлийг тулган баталгаажуулж ажилласан.

Санхүүгийн хяналт, аудитын хэлтэс:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц

- Аймгийн Засаг даргын баталсан 2022 оны санхүүгийн хяналт шалгалтыг, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.
- Аймгийн Засаг даргын баталсан 2022 оны төлөвлөгөө, албаны даргын баталсан 01 тоот удирдамжийн дагуу Сайншанд сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020, 2021 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж дуусгасан.

- Албаны даргын баталсан 09 тоот удирдамжийн дагуу Хөвсгөл сумын төсөвт байгууллагуудын 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 09 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.
- 2022 оныг Чадавхижуулах жил болгон зарласантай холбогдуулан тус жилийн хүрээнд зохион байгуулагдах суралтын төлөвлөгөөний дагуу Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумдын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга, төсөвт байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч, нягтлан бодогч, нярав, төрийн сангийн мэргэжилтэнүүдийг хамруулсан Төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нэгдсэн нэг ойлголттой болж, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, харилцан туршлага судлах сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 16-аас 17-ны өдрүүдэд Хөвсгөл суманд зохион байгуулсан.
- Замын-Үүд сумын иргэний санал, албаны даргын баталсан 10 тоот удирдамжийн дагуу Чандмань бадрал ОНӨХХК-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж байна.
- Монгол Улсын шилэн дансны тухай хуульд заасны дагуу 2022 оны эхний хагас жилийн шилэн дансны мэдээлэлд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн.
- Актын төлбөрийн барагдуулалт 2923,4 мянган төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлсэн.
- Монгол улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийгдсэн “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт” сэдэвт аудит хийгдсэн ба тухайн аудитад шаардлагатай бүхий л мэдээлэл, судалгааг гаргаж Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 268, 271, 277 тоот албан бичгээр хүргүүлж хамтарч ажилласан.

-

Статистикийн хэлтэс:

- **Зорилтод арга хэмжээний хэрэгжилтийн явц:**
Дорноговь аймгийн нийгэм, эдийн засгийн 2022 оны 08 дугаар сарын танилцуулгыг боловсруулж, 600 гаруй хэрэглэгчдэд цахим болон хэвлэмэлээр тархааж, хэлтсийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулсан. Мөн орон нутгийн телевизтэй хамтран иргэд, олон нийтэд хүргэв.
- Долоо хоног бүрийн даваа гаригт судалдаг гол нэр төрлийн 32 нэр төрөл, нэмэлтээр 54 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг Сайншанд сумын хүнсний зах, дэлгүүрээс судалж, мэдээний PPI програмд шивэн, хугацаанд нь Үндэсний Статистикийн хороонд дамжуулав. Мөн 14 сумаас гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг судалж танилцуулга бэлтгэн 600 гаруй хэрэглэгчдэд цахимаар тогтмол тархааж байна.
- Хэрэглээний үнийн 238 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг аймгийн төвөөс, 142 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг Айраг, Даланжаргалан, Эрдэнэ, Замын-Үүд, Хатанбулаг сумдаас тус тус цуглуулан авч мэдээг хугацаанд нь Үндэсний статисникийн хороонд дамжуулав.
- Өрхийн нийгэм, эдийн засаг, Ажиллах хүчний 9-р сарын судалгааг Замын-Үүд, Дэлгэрэх, Иххэт, Даланжаргалан, Сайхандулаан, Улаанбадрах, Алтанширээ, Эрдэнэ, Хөвсгөл, Сайншанд сумдын 128 өрх хамрагдаж, мэдээлийг бүрэн цуглуулж, боловсруулан Үндэсний статисникийн хороонд дамжуулсан.

Хүн амын богино хугацааны хөдөлгөөнийг тандах туршилтын судалгааны ажлыг эрчимжүүлэх, хүн ам, өрхийн мэдээллийн санг сайжруулах зорилгоор Сайншанд, Замын-Үүд сумдын багийн бүртгэл мэдээллийн 14 ажилтанд онлайн болон танхимаар 2022 оны 09 дүгээр сарын 27,28-ны өдрүүдэд сургалт, мэдээлэл өгч ажилласан.

Татварын хэлтэс:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц

- Улс ба орон нутгийн төсөвт 7360,0 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн.
- Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу 2022,09,19-2022,09-21 өдрүүдэд төлбөрийн баримт олголтод хяналт шалгалт хийн ажилласан.Шалгалтаар нийт 478 татвар төлөгч хамрагдсан ба урд болон тайлант оны нийт 59,225,746 төгрөг төвлөрүүлсэн.Төлбөрийн баримт огт олгоогүй 17 татвар төлөгчдөд зөрчлийн хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч ажилласан.
- Тайлант хугацаанд цахим татварын мэдээллийн шинэ системийг хэрэгжүүлэн 7 төрлийн нийт 1478 татварын тайлан, 256 хүсэлтийг хүлээн авч ажилласан. Тайлант сард 70521288 нэгдсэн дуудлагын дугаараар 491, өрөөгөөр 641 татвар төлөгчдөд Татварын хууль, НӨАТ-ын урамшууллын систем, Цахим татварын мэдээллийн шинэ системийн заавар зөвлөгөө сурталчилгаа хийж үйлчилгээ үзүүлсэн. . .
- Дорноговь аймгийн Авто тээврийн төвийн нээлттэй хаалганы өдөрлөгт Татварын хэлтэс оролцож авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвартай холбоотой нийт 74 иргэдэд үйлчилгээг үзүүлсэн. 10 иргэн хуульд заасны дагуу улсын бүртгэлээс хасуулах тодорхойлолт гаргуулсан.

Орон нутгийн өмчийн газар :

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогыг 2022 онд явуулахаар шийдвэрлэгдсэний дагуу тооллогын нэгтгэлийг 100 хувь хийж гүйцэтгэсэн. Дорноговь аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 07/04 дугаар тогтоолын дагуу 1 автомашины дуудлага худалдааг 2022 оны 09 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан.
- Нийт 2 ажлын тендерийг зохион байгуулж, үнэлгээ хийж, хариу мэдэгдэл хүргүүлсэн. АЗ-ын сургалт зохион байгуулсан. 13 тендерийн баримт бичгийн иж бүрдлийг хийсэн. 2013-2021 он хүртэлх тайланг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.

ЗУРГАА. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

№	Хэрэгжүүлэх үйл	Хугацаа
---	-----------------	---------

ажиллагаа		
Нэг. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр:		
1	Шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, бүртгэл хөтлөх, удирдлагуудад танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавих	Монгол Улсын Засгийн газрын 2 тогтоол, 1 хуралдааны тэмдэглэл, аймгийн ИТХ-ын 4 тогтоол зэргийг тус хяналтад авч, удирдлагуудад танилцуулсан.
Хоёр. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр:		
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтээс эрчимжүүлэх шаардлагатай заалт арга хэмжээг нэгтгэж, удирдлагууд танилцуулан, хэлтсүүдэд чиглэл өгөх	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эхний хагас жилийн тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийн, 0, 30, 70%-тай хэрэгжүүлэн ажилласан 31 заалт арга хэмжээг хэлэтс тус бүрээр гарган, эрчимжүүлж ажиллах чиглэлийг хүргүүлсэн. 9 сард тайлагнах 29 заалт арга хэмжээ хуваарилагдсан ирснийг холбогдох хэлтсүүдэд хуваарилсан. Хэрэгжилтийг 10 сарын 03-ны өдөр нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд баталгаажуулна.
3	Аймгийн Засаг даргаас сайд нартай байгуулсан гэрээнээс эхний хагас жилийн байдлаар хийгдсэн 10 сайдын гэрээний хэрэгжилтийн ХШҮ тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах чиглэлийг хэлтсүүдэд өгөх	Аймгийн Засаг даргаас Засгийн газрын гишүүдтэй байгуулсан гэрээнээс эхний хагас жилийн байдлаар 10 сайдын гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, зарим арга хэмжээг эрчимжүүлэх зөвлөмжийг тухай бүр хүргүүлэн ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах чиглэлийг удирдлагын мэдээлэл дээр танилцуулан, дундын чаат-д байршуулж, хяналтдаа авч хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах чиглэлийг хүргүүлсэн.
4	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан, аймгийн Засаг даргын 2020 оны А/280 дугаар захирамжийг шинэчлэх	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсонтой холбогдуулан, аймгийн Засаг даргын 2020 оны А/280 дугаар захирамжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулан, Засаг даргын Тамгын газрын даргад хянуулахаар хүргүүлсэн.
5	Дээд шатны	Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын

	байгууллагаас ирсэн тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгаврын нэгдсэн судалгааг гарган, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих	газарт 2022 оны байдлаар Монгол Улсын Засгийн газрын 40 тогтоол, 26 хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1 зарлиг, Монгол Улсын Ерөнхий сайдын 3 албан даалгавар ирүүлснийг хяналтад авч тухай бүрд нь удирдлагуудад танилцуулан, ХШҮ-ний Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн эхний хагас жилийн хэрэгжилтээр тайлагнаж 94.6 хувьтай үнэлүүлэн 30, 70%-тай заалтуудыг ялгаж холбогдох хэлтсүүдэд эрчимжүүлэн ажиллах чиглэлийг өгсөн.
6	Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газраас агентлаг байгууллагуудад өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, хариуцлагыг сайжруулах	Байгаль орчин аялал жуулчлалын газрын мод үржүүлгийн газрын үйл ажиллагаатай танилцах, ажлаа эрчимжүүлэх үүрэг чиглэлийг ХБТХОХ-ийн ахлах мэргэжилтэн Н.Бямбацэцэгийн хамт гүйцэтгэсэн. ХХААГ, ГХБХБГ, МЭГ зэрэг байгууллагууд нь тухайн сард гадагшаа чиглэсэн ажил арга хэмжээ /Намрын ногоон өдрүүд, Барилгачдын баяр, вакцины ажил/ ихтэй байсны улмаас хяналт шалгалтын ажил хийгдээгүй.
<i>Гурав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын чиглэлээр:</i>		
7	Шинээр томилогдсон болон албан тушаал өөрчлөгдсөн албан хаагчдын судалгааг гаргах, хяналт-шинжилгээний үнэлгээний цахим санд ажиллах эрх нээлгэх	Алтанширээ сумын 2, Улаанбадрах сумын 3, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 1, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 1, Төв номын сангийн 1, хэлтсийн шинэ мэргэжилтэн нийт 9 албан хаагчдын мэдээллийг “Ухаалаг засаглал ТББ”-руу илгээж, нэвтрэх, тайлагнах эрхийг үүсгэсэн.
<i>Дөрөв. Төрийн албаны нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр:</i>		
8	Хэлтсийн сарын төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжүүлж ажиллах	Хэлтсийн 7 сарын төлөвлөгөөг боловсруулан, ЗДТГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг хяналтад авч ажилласан. 7 хоног бүрийн тайланг нэгтгэн, хамт олны мэдээллийн цагаар танилцуулсан. Сарын тайланг нэгтгэн, ТЗУХ-т хүргүүлсэн
9	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн ажлыг шуурхай хийж гүйцэтгэх	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын чадавхийн мэдээллийг нэгтгэн хүргүүлсэн. Шударга байдлыг түвшний үнэлгээний судалгааг бөглөн ХЭЗХ-т хүргүүлсэн. Аймгийн МАН-ын мөрийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн

		<p>хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн удирдлагуудад танилцуулсан.</p> <p>Аймгийн Төрийн аудит-д аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жилийн эцсийн биелэлт тус бүрд ХШҮ хийсэн тайлан, 2022 оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эхний хагас жилийн тайланд ХШҮ хийсэн тайланг тус тус хүргүүлсэн.</p> <p>Байгууллага хамт олноос зохион байгуулсан “Мартагдашгүй намар” арга хэмжээнд оролцсон.</p>
10	<p>Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх, ирсэн албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэх</p>	<p>Дорноговь аймгийн хэмжээнд 2022 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 13 дэд болон зорилтот хөтөлбөрийн судалгааг гаргаж, жилийн эцсийн тайлагнах хуваарийн хамт холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн.</p> <p>Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа хийх аргачлал, гэрээ, асуулт зэргийн төслийг боловсруулсан.</p> <p>“Үр дүнд суурилсан төлөвлөлт болон төлөвлөлтийн арга зүй” сургалт семинарт хамрагдсан.</p> <p>Хэлтэст ирсэн 2 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан.</p>